



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 12 өдөр

Дугаар А/А17

Булган сум

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны “Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай” IV/26 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг шинэчлэн батлах тухай” А/648 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Архангай аймагт зохион байгуулагдах хангайн бүс (Архангай, Өвөрхангай, Булган)-ийн аймгуудын хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах сургалтын шатахуун, томилолтын зардалд дэмжлэг үзүүлсүгэй

2.Сургалтад оролцоход шаардлагатай 324,800 (гурван зуун хорин дөрвөн мянга найман зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын 2025 оны хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээ хэрэгжүүлэх зардлын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны
11 дүгээр сарын 12-ны/ний өдрийн
А/НТ дугаар захирамжийн хавсралт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол,
нийгмийн хамгааллын салбар комиссын гишүүдийг чадавхжуулах
Хангайн бүсийн аймгуудын сургалт

д/д	Зардлын төрөл	Тоо, хэмжээ	Нэг бүрийн үнэ	Бүгд
1	2	3	4	5
1	Шатахуун /Булган аймаг - Архангай аймаг/ /Архангай аймаг – Булган аймаг/ нийт 600 км	л	2720	244,800
2	Томилолт /2 хоног/	1	40,000	80,000
	Дүн			324,800